



205

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 38

Есөнбулаг сум

Цогт сумын Ар чулуут нэртэй талбайд ашигт  
малтмалын хайгуулын лиценз хүссэн  
өргөдөлд санал өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цогт сумын нутаг Ар чулуут нэртэй талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс дэмжихгүй байгааг үүгээр уламжилсугай.

2. Уг шийдвэрийг холбогдох материалын хамт Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  .ТАНЗОРИГ